



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/438

Ховд

Аймгийн музейн бүтэц, орон тоог
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.2.12, 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн музейн бүтэц орон тоог хавсралтаар баталсугай.
2. Хавсралтаар батлагдсан бүтэц орон тоог цалингийн сан, батлагдсан төсөвт багтаан байгууллагын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг аймгийн музейн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Гэрэлмаа)-д үүрэг болгосугай.
3. Шинээр нэмэгдэх орон тооны цалинг холбогдох дээд шатны байгууллагад уламжилж, цалингийн сан шийдвэрлэгдсэн тохиолдолд авч ажиллуулахыг аймгийн музейн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Гэрэлмаа)-д үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Баасанхүү)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.АМАРСАНАА



8400001 1310

Zah A/438 Och

Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А/438 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН МУЗЕЙН БҮТЭЦ, ОРОН ТОО

Д/д	Албан тушаалын нэр	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Орон тоо
1	Захирал	ТҮСБ-6	1
2	Бүртгэл мэдээллийн санч	ТҮСБ-4	1
3	Сан хөмрөгч	ТҮСБ-4	1
4	Эрдэм шинжилгээний ажилтан	ТҮСБ-4	1
5	Арга зүйч	ТҮСБ-4	1
6	Тайлбарлагч	ТҮСБ-4	1
7	Боловсролын ажилтан	ТҮСБ-4	1
8	Сэргээн засварлагч	ТҮСБ-4	1
9	Куратор	ТҮСБ-4	1
10	Үзмэр хянагч, үйлчлэгч	ТҮСБ-2	1
11	Нягтлан бодогч	ТҮМ-7	1
12	Архив, бичиг хэрэг, хүний нөөц	ТҮ-4	1
13	Соёлын өвийг харгалзан хамгаалагч	ТҮСБ-2	1
			13
Шинээр нэмэгдэх орон тоо			
14	Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан- менежер	ТҮСБ-3	1
15	Үйлчилгээний зохион байгуулагч	ТҮСБ-2	1
16	Нярав	ТҮ-4	1
17	Мужаан-цахилгаанчин, сантехникч	ТҮ-3	1
18	Өв соёлын хүрээлэнгийн ажилтан	ТҮ-1	1
			5
Нийт ажилтан			18

-оОо-